



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажил эрчимжүүлж, гүйцэтгэл
сайжруулах тухай

Тус яамны газар, хэлтэс болон харьяа байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарт хэрэгжиж буй дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэхэд зарим зорилт арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн биелэлт бүрэн хэрэгждэггүй, зохион байгуулалтын арга хэмжээ оновчгүй, тайлагналт хангалтгүй, гүйцэтгэлийн үр дүнг үнэн бодитоор дүгнэж хэвшээгүй, сахилга хариуцлага тооцдоггүйгээс төлөвлөгдсөн зорилт, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй, удаашралтай, удаа дараа он дамжин хэрэгждэггүй, бодлогын асуудалд онцгойлон анхаарч ажиллахгүй байгааг дүгнэн албан даалгавар хүргүүлэх үндэслэл болж байна.

Иймд яам, холбогдох байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, ажлын үр дүн, гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төрийн бүх шатны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Яамны бүх газар, хэлтэс, харьяа газруудад

1. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дараах бодлогын баримт бичгүүдийн зорилт арга хэмжээ, хүрэх үр дүн, тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажлын дагуу тусган, үр дүнтэй хэрэгжүүлж, хуулийн хугацаанд үнэн зөв, хэрэгжүүлсэн ажлаа баримт нотолгоотой, шаардлага хангахуйц тайлагнаж хэвших. Үүнд:

- 1.1 Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал 2030,
- 1.2 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- 1.3 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл,
- 1.4 Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө,
- 1.5 Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрүүд,
- 1.6 Төрөөс баримтлах бодлогууд,
- 1.7 Бүсчилсэн хөгжлийн бодлого,
- 1.8 Гурван тулгуурт хөгжлийн бодлого,
- 1.9 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр,
- 1.10 Үндэсний хөтөлбөрүүд,
- 1.11 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн хэрэгжилт гэх мэт;

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл оруулах үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд нь хуулийн хэрэгжилтэд анхаарч, цаг хугацаанд нь бүрэн гүйцэд мэдээллийг оруулж, нэгжийн дотоод хяналтыг сайжруулах;

3. Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад төсөв, санхүүтэй холбоотой хууль эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн сар, улирлын мэдээ, санхүүгийн тайлан, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүн, тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлтийн тайланг цаг хугацаанд нь үнэн зөв тайлагнах, холбогдох материалыг бүрэн бүрдүүлж архивлаж хэвших;
4. Төсвийн хуваарилалт, зарцуулалт, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж, санхүүгийн сахилгыг чанд сахих;
5. Дараа оны төсвийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн боловсруулж батлуулах, хяналт тавих;
6. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнаж хэвших;
7. Байгаль орчин, мэдээллийн сангийн мэдээ бүрдүүлэлтэд эрх бүхий албан хаагч мэдээгээ тухай бүрд нь үнэн зөв оруулж хэвших, мэдээллийг баяжуулах;
8. Засгийн газрын "Төрийн албаны сахилга хариуцлага дэг журам чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу бүх албан хаагчид ажлын цаг бүртгэлийн системд бүртгүүлэх, гадуур ажлын тэмдэглэл хөтлөх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;
9. Яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг хангаж, тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг тус яамны цахим хуудсанд байрлуулан, тухай бүр шинэчлэх;
10. УИХ, ЗГХЭГ, Яамд болон бусад байгууллагаас ирсэн хугацаатай албан бичиг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, дотоод сүлжээнд хаалтын тэмдэглэлийг гүйцэтгэж хэвшүүлэх;
11. Мэргэжилтэн бүр гаргасан тайлан, мэдээллийн үнэн бодит байдалд бүрэн хариуцлага хүлээх чадвартай байх;
12. Төрийн албанд мэргэших, холбогдох сургалтад хамрагдах, өөрийн мэдлэгийг дээшлүүлэхэд мэргэжилтэн бүр идэвх санаачилгатай, ёс зүйтэй ажиллах;
13. Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал бууруулахгүйгээр ажлын зайлшгүй шаардлага, удирдлагын шийдвэрээр байгаль орчны салбар хооронд өөр албан тушаалд шилжүүлэн томилох, сэлгэн ажиллуулах;
14. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгах;
15. Удирдлага, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг улирал тутам тайлагнаж, хагас, бүтэн жилээр үнэн зөв, бодитоор дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн урамшуулал, хариуцлага тооцон ажиллах;
16. Нэгжүүдийн удирдах албан тушаалтнууд эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж, хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, удирдлагын манлайллыг ханган ажиллах, бүрэн хариуцлага хүлээх чадвартай байх;
17. Албан даалгаврыг яамны нэгж, харьяа байгууллагуудад танилцуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Цогтсайхан/-т, албан даалгаврын биелэлтийг улирал бүр ирүүлж байхыг яамны нэгж, харьяа байгууллагуудад, хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар /В.Жавзан/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ